

Монгол Улс
НЭЗХДШ болон ТС-ийг боловсруулах хүрээнд Дархан-Уул аймгийн иргэний нийгмийн
байгууллагууд, эрдэмтэд, судлаачидтай хийсэн зөвлөлдөх уулзалт
2017 оны 9-р сарын 7

Тус тэмдэглэл нь уулзалтын явцад дэвшүүлсэн асуудлын товч, албан бус тойм юм. Хэрвээ та энэ уулзалтанд оролцсон бөгөөд тэмдэглэлд засвар оруулах эсвэл нэмж мэдээлэл өгөхийг хүсвэл ibaatarkhuu@worldbank.org и-мэйл хаягаар Б. Индратай холбогдоно уу.

Дэлхийн Банк Групп (ДБГ) нь Монгол Улсын хөгжлийн боломж, сорилт, тулгамдсан асуудал болон ДБГ-ээс Монгол Улсад үзүүлж болох дэмжлэгийн талаар санал бодол сонсох, солилцох зорилгоор 2017 оны 9 дугаар сарын 7-нд Дархан-Уул аймгийн 15 иргэний нийгмийн байгууллага, эрдэмтэн судлаач нартай уулзлаа.

Хэлэлцүүлгийг дараах үндсэн гурван асуудлын хүрээнд хийлээ:

- 1) Таны бодлоор Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг хангахад ямар гол боломж, сорилт, бэрхшээл тулгамдаж байна вэ?
- 2) Таны бодлоор дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсын хөгжлийн нэн тэргүүний зорилго юу байх вэ?
- 3) Дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг тогтвортойгоор хангахын тулд ДБГ (Дэлхийн Банк, ОУСК, ОТХОБА) Монгол Улсад хэрхэн тусалж, дэмжлэг үзүүлэх нь зүйтэй гэж та үзэж байна вэ?

Ангилал	Оролцогчдын санал
Улс орны хөгжлийн дүн шинжилгээ (ядуурлыг устгаж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжих арга зам, боломж, сорилт, бэрхшээл)	<p>Боломж:</p> <ul style="list-style-type: none">• Аймгийн хувьд уул уурхайн салбарыг хөгжүүлэх том боломж байна: алтны 70 орчим лиценз байдаг ба төмрийн хүдрийн томоохон орд байдаг.• Сүүлийн жилүүдэд өсөлтийг хангасан хүчин зүйлст хөдөө аж ахуй, Монгол Улсын гадаадаас авсан зээл болон гадаадад ажиллаж буй Монголчууд багтаж байна.• Байгаа ордууддаа түшиглэн улс орны хөгжилд металлургийн салбар хувь нэмэр оруулах боломжтой. Ур чадвартай боловч илүүдэл болсон ажиллах хүчнийг уг салбарт шингээж, илүү их ажлын байр бий болгох боломжтой. <p>Сорилт, бэрхшээл:</p> <ul style="list-style-type: none">• Улс төрийн тогтворгүй байдал урт хугацааны төлөвлөлтийг хязгаарлаж байна. Богино хугацааны, алсын хараагүй бодлогууд нь улс орны хөгжлийг боомилж байна. Засгийн газар, олон нийт хооронд харилцаа холбоо бараг тогтоогүй учраас хүмүүсийн амьдрал, Засгийн газрын бодлого хоорондоо уялдаа холбоогүй байдаг. Урт хугацааны бодлогыг хэрэгжүүлэх боломж дутмаг байна.• Уул уурхайн салбараас орж ирж буй орлогыг тэгш хуваарилахгүй байгаагаас ядуурал, ажилгүйдэл үүсч байна.• Мэдээлэл ил тод бус байдгаас болж авлига тулгамдсан асуудал болсон. Худалдан авах ажиллагааны зарууд ажил гүйцэтгэх боломжтой аж ахуйн нэгжүүдэд очдоггүй гэдэг нь худалдан авах үйл ажиллагаа ил тод

	<p>явагддаггүй гэдгийг гэрчилнэ. Төрөл бүрийн төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилт авлигал, залилан зэргээс болж зорилтот хүмүүстээ хүрч чадахгүй байх шиг байна.</p> <ul style="list-style-type: none"> • Бэлчээрийн менежментийн зөв бодлого, зохицуулалт байхгүйгээс болж бэлчээрийн даац хэтрэх явдал томоохон асуудал болж байна. Дарханд байгаль орчны асуудлууд тулгамдсан асуудал болоод байна. Ферм, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний чанар доройтож байгаа нь хөдөө аж ахуйн салбарын сүлжээг системчилсэн байдлаар харах, салбарт тулгамдаж буй асуудлуудыг бүхэлд нь авч үзэх шаардлагатай болсныг харуулж байна. • Дархан бол залуусын хот. Гэсэн ч залуусын нөөц бололцоог хангалттай ашигладаггүй, залуусын дундах ажилгүйдэл өндөр байгаа нь настайчуудад дарамт болж байна. Зарим тохиолдолд ажлын байр байхгүйгээс залуучууд ажил хайж, том хот руу явж байна. Олон хүмүүс гадаадад ажиллахаар явж байна. Боловсрол болон залууст чиглэсэн энтэрпренер, бизнесийн боломж хомс байна. • Иргэний нийгмийн байгууллагууд, хэвлэл мэдээлэлд чиглэсэн дэмжлэг бага байдаг. Жижиг хэмжээний иргэний нийгмийн байгууллагуудын санхүүжилт, хамрах хүрээ хязгаарлагдмал байна. Иргэний нийгмийн байгууллагууд ерөнхийдөө их идэвхтэй бөгөөд өөрсдийн ойр орчныхоо хөгжилд нэлээд их хувь нэмэр оруулдаг боловч тэднийг дэмжих, бэхжүүлэхэд чиглэсэн туслалцаа байдаггүй. Мөн иргэний нийгмийн байгууллагууд Засгийн газраас дэмжлэг, туслалцаа авдаггүй, өөрөө өөрсдийгөө болгох гэж хичээдэг. Төр засгийн өмнөөс иргэдэд үйлчилгээг үргэлжлүүлэн үзүүлэхийн тулд иргэний нийгмийн байгууллагуудад санхүүжилт хэрэгтэй. Мөн олон улсын ТББ-уудтай мэдлэг, туршлага солилцох боломжийг эрэлхийлэх хэрэгтэй. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд томоохон бүлгэм, улс төрчдийн нөлөөнд орсон, хараат бус байдлаа алдсан байна. • Хүний хөгжил, тэр дундаа хувь хүний хөгжлийн асуудлууд анхаарлаас гарсан. Юм болгоны ард хүний хүчин зүйл байдаг. Хүмүүс эрүүл, боловсролтой байх ёстой. “Үр бүтээлтэй Монгол хүн – Үр бүтээлтэй инженер” зэрэг орон нутгийн хөтөлбөрүүд хэрэгждэг ч, ур чадвартай төрийн албан хаагчид зэрэг ажилчдын цалин ур чадвар шаарддаггүй, бичил уурхайд олборлолт явуулдаг хүмүүсийхтэй л дүйцэж байна. • Хөдөлмөрийн зах зээл дээрх эрэлтийн талаар судалгаа дутмаг байгаа нь дээд боловсролын салбарыг хөгжлийг арагш татаж байна. Олон салбарт техникийн боловсролтой мэргэжилтнүүд дутагдаж байгаа боловч оюутан залуус эдгээр салбарт ажиллахаар суралцахгүй байна. • Иргэний боловсрол, тэр дундаа гэр бүлийн хүмүүжил, ёс зүйн боловсрол анхаарлаас гарсан. Номын сангийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга гэх зэрэгт хөрөнгө оруулалт бага байдгаас хүмүүсийн мэдээлэл авах, унших боломж хомс байна. • Насан туршийн боловсролыг мөн дэмжих хэрэгтэй, насан туршийн боловсролын бодлого нь гэр бүлийн төлөвлөлт, сургуулийн өмнөх боловсрол, хүмүүжил зэрэгт төвлөрөх хэрэгтэй. Гэр бүл, хүмүүжлийн Монгол уламжлалт соёл, уламжлалыг сэргээх хэрэгтэй.
--	---

	<ul style="list-style-type: none"> • Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтэц дутмаг байдгаас тэдгээр хүмүүс идэвхтэй амьдрах, нийгэмд бүрэн дүүрэн оролцох, төрөл бүрийн үйлчилгээ авах боломж хомс байна. • Хөдөлмөрийн зах зээл дээрх эрэлт хэрэгцээний судалгаа хийгдээгүй болохоор эрэлт, нийлүүлэлт зохицуулагддаггүй. Хүмүүст зориулан хийж байгаа аливаа сургалт тэдэнд бодит ур чадвар авахад төвлөрөх хэрэгтэй. • Ахмадуудын зээлийн хүү маш өндөр байна. Худалдан авах чадварт нийцсэн орон сууцны боломж хомс бөгөөд үүнийг цааш судлах шаардлагатай, ингэснээр мөн агаарын бохирдлын асуудлыг шийднэ. Банкны салбар, санхүүжилт олох боломжийг ерөнхийд нь сайжруулах хэрэгтэй бөгөөд олон улсын сайн жишиг дээр үндэслэн санхүүжилтийн хүртээмжийн талаарх мэдлэг мэдээллийг түгээх боломжийг эрэлхийлэх хэрэгтэй.
<p>ДБГ-ын стратеги, түншлэлийн талаарх санал</p>	<p>Салбарууд:</p> <ul style="list-style-type: none"> • Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн гаргах аж үйлвэрүүдийг хөгжүүлэх. Улс орны хөгжилд хувь нэмэр оруулж буй гол 2 салбар байгаа бөгөөд үүнд уул уурхай болон хөдөө аж ахуй, мал аж ахуй орж байна. Үүнээс ХАА, мал аж ахуйг хөгжүүлэхэд илүү их төвлөрөх хэрэгтэй. • Ядуурлыг бууруулахын тулд албан бус секторуудыг албан сектор болгох шаардлагатай. • Хүний хөгжил: Хүний хөгжил, боловсролын асуудалд илүү их анхаарал тавих шаардлагатай, учир нь эдгээр нь бусад салбарыг хөгжүүлэх суурь болдог. Одоогийн замын түгжрэл бол машин түгжрэн үүссэн биш, оюун санаанд түгжрэл үүссэнээс болж байгаа. • Дээд боловсролын тогтолцоо шинэчлэгдэж байна. Улаанбаатар хотын сургууль, их дээд сургуулиудын ачааллыг тэнцвэржүүлэхийн тулд багшийн хөгжлийг нэн тэргүүнд авч үзэх шаардлагатай (тэр дундаа орон нутагт). Боловсрол, соёлын салбарт ажиллаж буй хүмүүсийг дахин сургалтанд хамруулах, чадавхийг нэмэгдүүлэх нь чухал. • Хүний хөгжлийг хангахын тулд албан боловсролоос гадна ёс зүйтэй хүн болж төлөвших нь энэ зэрэгцэх ач холбогдол бүхий асуудал юм. Байгаль орчиндоо санаа тавих нь бага наснаас суралцах, төлөвших ёстой. Насанд хүрсэн хүмүүсийн санаа бодлыг өөрчлөхөд амаргүй боловч ИНБ-ууд энэ чиглэлээр хамтран ажиллаж, мэдээлэл түгээх, олон нийтэд таниулах санхүүжилт байхгүй ч ажиллах боломжтой. Зарим ИНБ-уудын чадавх, туршлага маш өндөр байдаг тул тэдгээрийг ашиглах хэрэгтэй. • Уул уурхайн үйл ажиллагаа, байгаль орчин, нийгмийн нөлөөллийг хянахад олон нийт, ИНБ-уудын оролцоо сайжрах хэрэгтэй. Уул уурхайн үйл ажиллагааны дараах нөхөн сэргээлтийг цааш нэмж судлан, дэмжих хэрэгтэй. • Тав орчим жилийн өмнө үйлдвэрлэл, технологийн паркуудыг байгуулсан бөгөөд тэдгээрийг илүү сайн ашиглах хэрэгтэй. Суурь судалгаа хийхэд санхүүжилт, дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.

	<p>Арга зам, хэрэгжилт:</p> <ul style="list-style-type: none"> • Зорилтот хөтөлбөрүүдийг, жишээ нь хоршооллуудад чиглэсэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх. • Төслийн үр дүнгийн мониторинг, хяналтыг сайжруулахын тулд бүх төслүүдийн үр дүнг тайлагнах явц сайжрах хэрэгтэй. ДБГ-ын үр дүн, хяналт шинжилгээ, үнэлгээнд илүү их анхаарал тавих хэрэгтэй бөгөөд тэр дундаа төсөл хөтөлбөрүүд зорилтот хүмүүстээ хүрч байна уу, авлигаас болж санхүүжилт нь алдагдаж байна уу гэдгийг анхаарах хэрэгтэй.
Бусад	<ul style="list-style-type: none"> • Засгийн газрын хөтөлбөрүүдийн үр дүнг хянаж, хариуцлагыг тодорхой болгох хэрэгтэй. • Хөгжлийн туслалцааны төсөл, хөтөлбөрүүдийн тодорхой асуудлуудыг ярилцахын оронд үр дүнг сайжруулах тал дээр анхаарах хэрэгтэй. • ЖДҮ-үүдийг хөгжүүлэхэд чиглэсэн хөтөлбөрүүд цар хүрээ хязгаарлагдмал бөгөөд бизнесийн тодорхой салбар, эсвэл салбарын өрсөлдөх чадварыг сайжруулахад хангалттай хувь нэмэр оруулж чаддаггүй харин хүмүүсийн амьдрал, амьжиргааг сайжруулахад илүү тохиромжтой байх шиг байна.

Уулзалтын үеэр оролцогчдоос авсан товч судалгааны хариу:

1. Ирэх 10 жилийн хугацаанд ядуурлыг бууруулж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжихийн тулд Монгол Улс аль чиглэлээр хөгжихөд голлон анхаарах ёстой вэ? (Боломжит хариултуудаас 5 хүртэлх хариултыг сонгоно уу)

<input type="checkbox"/> Төрийн удирдлага, шинэтгэл	9	56%
<input type="checkbox"/> Ажлын байр бий болгох/хөдөлмөр эрхлэлт	9	56%
<input type="checkbox"/> Хувийн хэвшлийг хөгжүүлэх	7	44%
<input type="checkbox"/> Боловсрол	7	44%
<input type="checkbox"/> Авлигатай тэмцэх	7	44%
<input type="checkbox"/> Гадаадын хөрөнгө оруулалт	5	31%
<input type="checkbox"/> Байгаль орчныг хамгаалах, бохирдлыг хянах	5	31%
<input type="checkbox"/> Эрүүл мэнд	4	25%
<input type="checkbox"/> Эдийн засгийн өсөлт	3	19%
<input type="checkbox"/> Хөдөө аж ахуй, мал аж ахуй, ойн сан	3	19%

<input type="checkbox"/> Хотын хөгжил	3	19%
<input type="checkbox"/> Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах	3	19%
<input type="checkbox"/> Нийгмийн хамгаалал	3	19%
<input type="checkbox"/> Зам, тээвэр	3	19%
<input type="checkbox"/> Байгалийн нөөцийн удирдлага	3	19%
<input type="checkbox"/> Эрх тэгш боломжоор хангах	2	13%
<input type="checkbox"/> Хөдөөгийн хөгжил	2	13%
<input type="checkbox"/> Санхүүгийн зах зээл	2	13%
<input type="checkbox"/> Хүнсний аюулгүй байдал	1	6%
<input type="checkbox"/> Худалдаа, экспорт	1	6%
<input type="checkbox"/> Ус, ариун цэврийн байгууламж	1	6%
<input type="checkbox"/> Бусад	1	6%
<input type="checkbox"/> Гамшгийн эрсдэлийн удирдлага	0	0%
<input type="checkbox"/> Эрчим хүч	0	0%

2. Дараагийн 4-6 жилийн хугацаанд ДБГ Монгол Улсыг аль чиглэлд дэмжвэл хамгийн их үр дүнтэй гэж Та үзэж байна вэ? (Боломжит хариултуудаас 3 хүртэлх хариултыг сонгоно уу)

Хүний хөгжлийг дэмжих	10	67%
Бизнесийн орчинг сайжруулах чиглэлээр дэмжих	9	60%
Төрийн удирдлага, засаглалын чиглэлээр дэмжих	5	33%
Байгалийн нөөцийн удирдлага, байгаль орчныг хамгаалах чиглэлээр дэмжих	5	33%
Дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих	6	40%
Бүгд чухал	3	20%